



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 01/581

Хэрлэн сум

Чингис хааны Эш хөрөг залж,  
тахихад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингис хааны Эш хөрөг залж, тахихад 729,900 (долоон зуун хорин есөн есөн зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны.....дугаар сарын.....-ны  
.....дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардал	Тоо	
1	Хэвийн боов/идээ/	1	379,900
2	Эш хөрөг	1	350,000
	Нийт дүн		729,900